



2024 оны 1-р сарын 24

Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс

И-мэйл: [communications@amcham.mn](mailto:communications@amcham.mn)

Утас: +976 9811-1513

Вэб: <https://amcham.mn/publications/1>

### Хэвлэлийн мэдээ

## АмЧам Монгол “Монгол Улсын эрчим хүчний бие даасан байдалд хүрэх замнал” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулав.

УЛААНБААТАР ХОТ, Монгол Улс – Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам Монгол) 2024 оны 1-р сарын 23-ны өдөр “Монгол улсын эрчим хүчний бие даасан байдалд хүрэх замнал” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулав.

АмЧам Монголын 1-р сарын хэлэлцүүлэгт АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг (USAID)-ийн Төслийн удирдагч Майкл Эллис, Эрчим хүчний яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Б. Ерөн-Өлзий, Азийн хөгжлийн банкны Суурин төлөөлөгч Шэннон Коулин, Ньюком группийн Дэд бүтцийн асуудал хариуцсан захирал Д. Ганхуяг нар панелистаар оролцож, АмЧам Монголын ТУЗ-ийн тэргүүн Гари Биондо хэлэлцүүлгийг удирдан явуулав.

Уг хэлэлцүүлгээр Монгол улсын эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, сэргээгдэх эрчим хүчний салбарын хөгжил, эрчим хүчний шилжилтэд хувийн хэвшил ямар үүрэгтэй оролцох, салбарын хэтийн төлөвийн талаар санал солилцож, хэлэлцүүлэг өрнүүллээ.



АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн Төслийн удирдагч Майкл Эллис “Монгол улс эрчим хүчийг цэвэр аргаар үйлдвэрлэж, зах зээлийн суурь зарчмуудыг хэрэгжүүлснээр эрчим хүчний бие даасан байдалд хүрэхэд ойрхон байна. Зорилгодоо хүрэхийн тулд цаг алдалгүй ажиллах хэрэгтэй” гэж онцлов.

Эрчим хүчний яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Б. Ерөн-Өлзий өнөөгийн эрчим хүчний хэрэглээ өсөлттэй байгааг тэмдэглэж, оргил хэрэглээтэй үеийг давах дотоодын эрчим хүчний эх үүсвэр үгүйлэгдэж байгаа тухай хэлэв. Хэрэглээний өсөлтийг дагаад нийлүүлтийг хангах эх үүсвэр шаардлага тулгарсан нь үнэн, нөөц бололцоог бүрэн дүүрэн ашиглах, цаашлаад үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг хадгалах батерей хураагуурыг байгуулах төлөвлөгөө, ажил хийгдэх хэрэгтэйг онцоллоо.



Азийн хөгжлийн банкны Суурин төлөөлөгч Шэннон Коулин хэлэхдээ “Монгол улс сэргээгдэх эрчим хүчний шилжилтийг хийх нь гарцаагүй ба одоогийн эрчим хүчний системийг хөгжүүлж, хөрөнгө оруулагч нарын оролцоог хангахын тулд тухайн салбарт зориулсан цогц төлөвлөгөө болон санхүүгийн тогтвортой байдал зайлшгүй шаардлагатай болно” гэлээ.

Хувийн хэвшлийн төлөөлөл, Ньюком группын Дэд бүтцийн асуудал хариуцсан захирал Д. Ганхуяг “Алсын хараатай бодлого боловсруулж, оновчтой стратеги хэрэгжүүлж чадваас Монголын сэргээгдэх эрчим хүч улсын экспортын гол эх үүсвэр болох боломж ойрхон байна” гэдгийг хурлын төгсгөлд онцлов.

Хэлэлцүүлгийг хаах үеэр АмЧам Монголын шинэ гишүүн “Дэлхийн Зөн Монгол”, “Ремакс Платин”-ийн төлөөлөгч нарт баяр хүргэж, шинэ гишүүнчлэлийн өргөмжлөл гардуулав.



### **АмЧам Монголын тухай**

АмЧам Монгол АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн Ази Номхон далайн 29 орны Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.